

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-25
1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.07.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	5-15
2. Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан	16-25

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны
12 дугаар сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 31 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 58.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: М.Бадамсүрэн, Б.Жаргалан, Г.Очирбат, М.Энхцэцэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа;

Тасалсан: Ц.Баатархүү, Н.Батсүмбэрэл, Ж.Ганбаатар, П.Ганзориг, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Р.Сэддорж үг хэлж, хэлэлцэх асуудлын 3 дугаарт байгаа Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дарааллаас хасав.

Нэг.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан 2025.07.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчны ашиглалт, хамгаалалтын хэлтсийн дарга Н.Мөнхбаяр, мөн газрын Байгаль орчны хэлтсийн даргын албан үүрэг гүйцэтгэгч Д.Батзолбоо, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын ахлах шинжээч О.Амарсанаа, иргэдийн төлөөлөл Н.Гантөмөр, Г.Отгонбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, Х.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Ш.Бямбасүрэн, Ч.Анар, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын ахлах шинжээч О.Амарсанаа, Нийслэлийн Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчны ашиглалт, хамгаалалтын хэлтсийн дарга Н.Мөнхбаяр, мөн газрын Байгаль орчны хэлтсийн даргын албан үүрэг гүйцэтгэгч Д.Батзолбоо, иргэн Н.Гантөмөр, Г.Отгонбаатар нар хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: 1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 7
Бүгд: 20
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 6
Бүгд: 20
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигч С.Наранцогт оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, Х.Шижирмөнх, М.Мандхай нар байлцав.

Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын дарга Н.Учрал, Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нар танилцуулав.

Нэр дэвшигч болон танилцуулга, сонсголын тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, М.Мандхай, Б.Жавхлан, Ч.Анар, Р.Сэддорж нарын тавьсан асуултад нэр дэвшигч С.Наранцогт хариулж, тайлбар хийв.

Р.Сэддорж: 1.Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд Санжаагийн Наранцогтыг томилохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Бядрангийн Лхагвасүрэнг Монголбанкны Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 5
Бүгд: 20
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Р.Сэддорж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 16 минут үргэлжилж, 31 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 64.5 хувийн ирцтэйгээр 17 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 16-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
16 цаг 15 минут.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан, Ренчиндоржийн Батболд, Пүрэвийн Батчимэг, Шинэбаярын Бямбасүрэн, Батжаргалын Заяабал, Чулуунбилэгийн Лодойсамбуу, Ганзоригийн Лувсанжамц, Мэндбаярын Мандхай, Бадрахын Найдалаа, Эрдэнэбилэгийн Одбаяр, Бадамдоржийн Пунсалмаа, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Ренчинбямбын Сэддорж, Агваанлуvsангийн Ундраа, Болдын Уянга, Саруулсайханы Цэнгүүн, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Отгоншарын Батнайрамдал нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 58,1 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан 2025 оны 7 сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх/

2.Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонголын тайлан

3.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудал энэ 7 хоногийн тов дараалалд орсон байгаа.

Үүнээс “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хувьд Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир хүсэлт ирүүлсэн.

“Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 3 дугаар тогтоолоор Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдэд төрийн үйлчилгээний нэгдсэн и-Монгол цахим системийг хүртээмжтэй болгох, сонгуульд цахимаар оролцох эрхийг хангах боломжийг судлан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан миний бие ахлан ажилласан.

Ажлын хэсгийн хүрээнд холбогдох 13 төрийн байгууллагыг оролцуулан мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүн байгуулж, шаардлагатай мэдээлэл, арга зүйг нэгтгэсэн болно.

Ажлын хэсгээс бэлтгэсэн санал, дүгнэлтэд тус ажлын хэсгийг үргэлжлүүлэн ажиллах дүгнэлт гарсан тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.11 дэх заалт, 13.2 дахь хэсэгт заасны дагуу дээрх ажлын хэсгийг Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор шинэчлэн байгуулж өгнө үү. Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан тус ажлын хэсгээс боловсруулсан санал, дүгнэлтийг хавсаргав. Хавсралт 4 хуудас, Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир Ажлын хэсгийн ахлагч.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт Байнгын хороо бол зөвхөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг Байнгын хороо чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж болохоор заасан байдаг. Харин хууль тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай асуудал нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.11-д зааснаар зөвхөн Улсын Их Хурлын даргын бүрэн эрхэд хамаардаг.

Тиймээс Бум-Очир гишүүний гаргасан хүсэлтийн дагуу Байнгын хорооны тогтоолоор ажлын хэсэг байгуулах асуудлыг хэлэлцэх нь хууль зөрчсөн асуудал болж болзошгүй тул өнөөдрийн хэлэлцэх хэлэлцэх асуудлаас хасаж байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

Хэлэлцэх асуудал 1.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хуулийн төслийн талаарх хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Ж.Алдаржавхлан: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Миний бие санаачлан боловсруулсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг танилцуулж байна.

Улаанбаатар хотын барилга, авто замын байгуулалтад ашиглаж байгаа хайрга, дайргын нийслэлийн нутаг дэвсгэрээс тодруулбал Туул голын сав газраас ихээр олборлож байна. Энэ байдал нь нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байгаа бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө жилээс жилд нэмэгдэж байна.

Тус хуулийн төслийг боловсруулахдаа иргэдийн санал, хүсэлт, Монгол Улсын Засгийн газраас усны сан бүхий газарт учруулсан хохирлын талаар холбогдох судалгаа, тэр дундаа түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт явуулснаас эвдэрч доройтсон газрын талаарх статистик мэдээллийг авсан бөгөөд мөн энэ чиглэлээр авсан арга хэмжээний талаарх мэдээллийг тус тус авсан болно.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийг харахад улсын хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын

олборлолтоос ухагдаж эвдэрсэн газрын хэмжээ 2021 оны байдлаар 11319 га, нийслэл хотод 2404 га байна.

Усны газраас ирүүлсэн мэдээллээр Туул голын сав газар, түүний дотор нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт явуулснаас эвдэрч доройтсон газрын хэмжээ 5137 га байна. Урт нэртэй хууль батлагдсаны дараа Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтооход хамгаалалтын бүстэй давхцалтай 46 аж ахуйн нэгжийн 2950 га газрын тусгай зөвшөөрлийг цуцалж шийдвэрлэсэн боловч тухайн газрууд нөхөн сэргээлт хийгээгүй орхисон байна.

Цаашдаа усны сан бүхий газарт түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, олборлох, ашиглах зөвшөөрөл олгохгүй байх, одоо үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг үе шаттай хязгаарлах бөгөөд энэ чиглэлийн эрх зүйн орчныг эргэн харах зайлшгүй шаардлага үүссэн тул энэхүү хуулийг санаачлан боловсрууллаа.

Тодруулбал, хуулийн 29.4-д орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагч бүх шатын Засаг дарга нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа талаарх гомдлыг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх тухай хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана гэж хуульчилснаар эрх ашиг нь хөндөгдөж байгаа зөрчигдөж буй иргэдээс гаргасан гомдлыг эрх бүхий байгууллага авч хэлэлцэх, хараат бус байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийх эрх зүйн орчин бүрдэх юм.

Түгээмэл харах ёстой ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаанд байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар дүгнэлт гарсан бол тусгай зөвшөөрлийг цуцлах зохицуулалтыг мөн хуулийн 37.1.5-д нэмж тусгахаар орууллаа.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 болон 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүсэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулахаар тусгалаа. Энэхүү нэмэлт орсноор Усны сан бүхий газраас хамгаалалтын бүсэд цаашид нэмж олголт хийгдэхгүй болох юм.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Оюунбаатарын Амарсанаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлого, үнэлгээний газрын ахлах шинжээч, Насанбатын Мөнхбаяр Нийслэлийн Байгаль орчны газрын Хүрээлэн буй орчны ашиглалт, хамгаалалтын хэлтсийн дарга, Дагмидын Батзолбоо Нийслэлийн Байгаль орчны газрын Байгаль орчны хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч, Сүрэнхүүгийн Сайнбаяр Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, иргэний төлөөлөл Намжимын Гантөмөр Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны иргэн, Гантөмөрийн Отгонбаатар Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны иргэн.

Хуулийн төслийн талаар хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгээр тасалъя. Улсын Их Хурлын гишүүн Уянга асуулт асууна.

Б.Уянга: Энэ өдрийн мэндийг хүргэе. Амарсанаа дарга л бараг хариулах болов уу даа. Сая Алдаржавхлан гишүүний танилцуулсан танилцуулга ерөнхийдөө зарчмын хувьд бол ойлгож байгаа. Тэгэхдээ яг шаардлагатай байгаа хууль, эрх зүйн орчин нь бол Монгол Улсад байгаа гэж бодож байгаа.

1 дүгээрт болохоороо ашигт малтмал яг энэ гол усан сан бүхий газруудад түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайлгахгүй, олборлуулахгүй гэсэн зохицуулалт нэмж тусгах гэж байна. Энэ маань болохоор нөгөө урт нэртэй хууль гэж ярьдаг, манай хуулийн угаасаа зохицуулалт бол өөрөө байгаа. 4 дүгээр зүйл нь. Тэгээд 2014 онд урт нэртэй хууль батлагдсан биш, урт нэртэй хууль чинь 2009 оных. Түгээмэл тархацтай болохоороо 2014 оных. Тэгэхээр ер нь одоо бол Ашигт малтмал газрын тосны газраас усан сантай давхцаж байгаа газар ямар ч дүгнэлт бол гардаггүй. Тэгэхээр 2014 оноос хойш Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиараа энэ нөгөө урт нэртэй хуультайгаа холбоотойгоор 1 ч хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоогүй байх ёстой. Тэгэхээр одоо энэ орж ирж байгаа асуудал нь болохоор аль хэдийн олборлолт нь эхэлсэн талбайнуудыг ярьж байгаа юм болов уу. Тэгэхээр яг энэ зохицуулалт бол урт нэртэй хууль дээр тусчихсан гэсэн үг.

Хоёрдугаарх нь болохоор орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт эрх өгч байна. Энэ маань болохоор Байгаль хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлтэй давхачихаж байгаа байхгүй юу. Байгаль хамгаалах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 27-д юу гэж дурдсан байдаг гэхээр байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, энэ улсын байцаагчийн эрх дээрээ байгаа. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох, тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл эрх хэмжээтэй байхаар хуульчилсан байгаа. Тэгээд мөн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дээр нь Засаг даргад энэ бүх мэдээллийг нь холбогдох газарт нь хүргэ гэсэн үүрэг нь байгаа. Тэгэхээр яг шаардлагатай байгаа хуулийн зохицуулалтууд нь хууль, эрх зүйн орчинд суучихсан юм. Хэрэгжилт нь харин хангалтгүй. Тэгэхээр одоо яаж хэрэгжүүлэхээр юм. Хэрэгжүүлэх субъект нь миний бодлоор бол Засаг дарга нар байх ёстой. Холбогдох байцаагч нар нь байх ёстой. Байгаль орчны ажилчид нь байх ёстой. Байцаагч нар нь. Тэгэхээр одоо яаж хэрэгжилтийг хангах вэ. Байгаль орчны яамнаас яг энэ чиглэлээр угаасаа хууль туссан юм чинь нэмээд Түгээмэл тархацтай хуульд яг ижилхэн агуулгаар ороход нэг их татгалзах зүйл алга. Гэхдээ ингээд хуульчлаад хуульчлаад хэрэгжихгүй байх тохиолдолд яах вэ.

Р.Сэддорж: Хариулт хэн хариулах вэ. Гараа өргөөрэй. 4 номер.

О.Амарсанаа: Уянга гишүүний асуултад хариулъя. Одоо бид нарын мэддэг урт нэртэй хуультай холбоотой давхцалтай талбай дээр бол 2014 оноос хойш нэмэлтээр талбай олгосон зүйл бол байхгүй байгаа. Манайхтай холбоотой ерөнхийдөө түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой санал авсан байгаа. Тодорхой саналуудыг гишүүд бол гаргаад холбогдох мэдээллүүд өгсөн байгаа.

Бид нарын өнөөгийн ярьж байгаа энэ асуудал болоод ирэнгүүт яг энэ Туул гол дагасан Улаанбаатар хот орчмын түгээмэл тархацтай ашигт малтмалтай холбоотой асуудлуудыг бас энд нэлээн түлхүү хөндөж ярьж байгаа ийм асуудал байгаа.

Р.Сэддорж: Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Одоо тэгэхээр яг энэ зохицуулалт Алдаржавхлан гишүүн ээ, яг энэ зохицуулалт Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт байдлаар орж ирэхээр Туул гол дагасан, одоо яг олборлож байгаа ч юм уу, ашиглаж байгаа тэр тусгай зөвшөөрлүүд хүчингүй болно гэсэн үг юм уу. Зохицуулалт нь яг яаж явах юм. Угаасаа нэмэлтээр бол талбай 2014 оноос хойш олгогдоогүй байхгүй юу.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн хариулна.

Ж.Алдаржавхлан: Уянга гишүүний санал бол зөв. Гэхдээ яг 2021 онд Урт нэртэй хууль батлагдаад, 46 аж ахуйн нэгж газрыг цуцалсан байгаа юм. Туул голын эрэг дагуу ярьж байгаа. Аймаг орон нутагт бол зөндөө олон байгаа байх. 46 аж ахуйн нэгж хайрга, дайрга олборлож байсан. Яг гол эрэг дээрээс. Тэгээд 200 метрт хязгаарласан. 200 метр бол хангалтгүй байна гэж үзэж байгаа. Өнөөдөр энд сууж байгаа иргэд бол яг манай Био, шувуу, сонгинын бүсэд амьдарч байгаа. Энэ хуулийн сөрөг нөлөөллөөс болж хохирсон иргэд байгаа. Тэгэхээр бид нарын хувьд хууль санаачлахдаа мэдээж энийг бас сунгах нь зүйтэй байна гэж үзэж байна. 200 метр бол энэ хананаас тэр хананы хоорондох зайд бол яг суурьшлын бүсдээ залгачихсан байж байгаа. Хашааг нь тойруулаад ухаж байгаа. Би бас хэдэн зураг авчирсан. Би одоо бас чуулганы хурал дээр үзүүлье гэж бодож байгаа. Тэнд амьдардаг иргэд ч гэсэн/минут дуусав/

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүнд 1 минут.

Ж.Алдаржавхлан: Бид нар бас юугаа сунгах юм бол дахиад 47 аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрөл нэмэгдэж орох юм байгаа. Нийслэлийн байгаль орчны газраас гаргасан судалгаагаар. Тэгээд ер нь бол зөвхөн бас нийслэл гэж харж болохгүй. Би бас Байгаль орчны яамнаас бас энд бас оролцооч ээ гэж Батбаатар сайд руу утсаар 2, 3 удаа ярьсан. Тэгээд Батбаатар сайд маань сайн хангалттай оролцож өгөхгүй байгаа юм. Байгаль орчны сайд маань. Тэгээд хуулиа бол манай иргэдийн хүсэлтээр, нийслэлчүүдийн хүсэлтээр би энэ хуулийг боловсруулсан гэж үзэж байгаа. Одоо бол 46 аж ахуйн нэгж, байгууллагаас бүгд зогсчихсон байж байгаа. Тэгэхдээ нөхөн сэргээлт хийхгүй, хаяад явчихсан байж байгаа. Бид нар энэ хуулийг хэлэлцэж эхэлсний дараа ажлын хэсэг байгуулаад, нөхөн сэргээлтийн асуудлыг бас давхар оруулах нь зүйтэй гэж үзэж байгаа. 46 аж ахуйн нэгж, байгууллага бүгд лиценз нь хүчингүй болмогц хаяад явчихсан. Тэгээд энэ хуулийг бид нар хэлэлцэж эхлээд, нөхөн сэргээлтийн асуудлыг оруулаад бас бүтэн сэргээж явах ёстой гэж үзэж байгаа юм. Энэ бол гарцаа байхгүй зайлшгүй .../минут дуусав/

Р.Сэддорж: Уянга гишүүн хариулт хангалтгүй гэж үзэж байгаа учраас тодруулж асууя.

Б.Уянга: 2014 оноос хойш л ер нь энэ усан сан бүхий газар урт нэртэй хуулийн дагуу шинээр тусгай зөвшөөрөл хайгуулынхан ч олгогдоогүй байх ёстой. Тийм дүгнэлт бол гараагүй. Хэрвээ олгогдсон байгаа тохиолдолд энэ бол яг аймаг, нийслэлийн Засаг дарга дээрх асуудал. Яагаад гэвэл түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрхийг нь зүгээр дүгнэлтийг нь л АМГТГ-аас гаргадаг. Тэгээд

яхах вэ, энэ зүгээр 200 метр гэж таны дурдаж байгаа болохоороо урт нэртэй хуулийг дагаж гаргах журмын тухай хууль дээр бол 250 байдаг л даа. 250 метр. Тэгэхээр тэрийг уул нь хөндөж орж ирэх ёстой байсан юм биш үү. Яг одоо орж ирсэн байгаа төслөөр болохоороо тэр хөндөгдөж орж ирээгүй. Тэгэхээр яг хэдэн метр байх нь бас зөв байгаа юм бол. Ер нь л хараад байхад холбогдох Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон урт нэртэй хуулиар таны хүсэж байгаа зохицуулалтууд суучихсан юм шиг. Тэгэхээр энэ журмуудыгаа ч юм уу, гүйцэтгэл, хэрэгжүүлэлт талдаа л анхаараад явчихвал болчих юм шиг санагдах юм.

Р.Сэддорж: Сая 4 номер хэн билээ. Амарсанаа юу. Мөнхбаяр байна уу. Мөнхбаяр хариулъя. 6 номер.

Н.Мөнхбаяр: Та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе. Хуулийн судалгаа бид нар нийслэлээс гаргахад бол 200 метр дээр нэмэх нь 500 ч гэдэг юм уу, 1км ч гэдэг юм уу судалгаа гаргаж үзлээ. Тэгэхээр 500 метрийн радиус ... татахаар бол нийтдээ яг өнөөдрийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа 15 аж ахуйн нэгжийн лицензийн асуудал бол хөндөгдөхөөр байна. 1км болох юм бол нийтдээ 47 аж ахуйн нэгжийн ашиглалтын лицензийн асуудал, түгээмэл тархцын асуудал бол хөндөгдөхөөр ийм судалгаа гаргасан байж байгаа.

Р.Сэддорж: Батзолбоо 5 номер.

Д.Батзолбоо: Манай нийслэлийн хэмжээнд бол нийслэлийн хэмжээнд ч юу байх вэ, ер нь бол урт нэртэй хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагдсанаас хойшоо бол нийслэлийн нутаг дэвсгэр дээр олгосон тусгай зөвшөөрлүүд дээр усны хамгаалалтын бүсэд бол олгоогүй. Харин усны хамгаалалтын бүсэд байсан тусгай зөвшөөрлүүдийг бол бүгдийг нь цуцалж, хүчингүй болгож шийдвэрлэсэн байгаа.

Р.Сэддорж: Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны иргэн Гантөмөр гуай та нэг нөхцөл байдлыг хэлээч. 7 номер. 8 юм байна. 8 номер.

Н.Гантөмөр: Эдийн засгийн байнгын хорооны гишүүд та бүхний амрыг эрж, амар амгаланг айлтгая. Миний нэр Намжин овогтой Гантөмөр, 12 дугаар хорооны иргэн байна. Би энэ нутаг дэвсгэр дээр 20 жил амьдарлаа. Өнөөгийн байгаа байдал бол Био Комбинат 12 дугаар хорооны Био комбинатаас эхлээд шувууны хойд энэ Сонгинохайрханы баруун урд үзүүрээс урагшаага оршин сууж байгаа айл өрхүүд рүү тулж очсон энэ олборлолтын үйл ажиллагаа. Дараа нь шувууны урд .../минут дуусав/

Р.Сэддорж: 8 номер 1 минут. Гантөмөр гуай хурдан ярихгүй бол 1 минутаар л байгаа.

Н.Гантөмөр: Тэгээд энд газрын байгаль орчинд учирсан эрсдэл бол маш их өндөр. Энэ яагаад вэ гэхээр зэрэг газраа ухаад, мөн тэр хөрсөө зайлуулаад шороогоо хаясан. Энэ газруудад бол бүгд нөхөн сэргээгдээгүй, орхичихсон. Ингээд байгалийн тэнцвэр алдагдсан ийм байдалтай байж байгаа. Ойр орчны оршин сууж байгаа иргэд бол шороондоо дарагдсан ийм байдалтай. Үер, үерийн юунд автагдсан Туул голын сав газарт Туул голын экологийн байдал алдагдсан ийм байдалтай ийм нөхцөл байдалд бид амьдарч байна.

Р.Сэддорж: Баярлалаа. Шинэбаярын Бямбасүрэн гишүүн.

Ш.Бямбасүрэн: Та бүгдэд энэ оройн мэнд хүргэе. Байгаль орчны яамнаас асуумаар байгаа юм. Усан сан бүхий газрын хил хязгаарыг ер нь хаанаас тогтоодог юм. Тэр ер нь наашлуулж, цаашлуулах асуудлын шийдвэрлэдэг эрх мэдэл нь ер нь хэнд байдаг юм. Энэ талаар хариулт өгөөч.

Ер нь тэгээд түгээмэл тархацтай ашигт малтмал дээр бол орон нутагт маш хүнд явдаг юм шүү дээ. Энэ угаасаа ерөөсөө юу бол байдаггүй. Тусгай зөвшөөрөл олгогддоггүй. Маш цөөхөн байдаг. Би бусад аймгуудыг бол мэдэхгүй байна. Гэхдээ сумуудад бол энэ түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл гэж бараг олгогддоггүй байх. Манай аймагт бол сумуудад яадаг вэ гэхээр айлууд хашаандаа байшингаа өргөтгөө. Улсын төсвийн хөрөнгөөр ч юм уу, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бүтээн байгуулалтын ажил хийгдье гэвэл нөгөө авдаг газраа бүгд мэддэг. Ямар ч зөвшөөрөл шаардагдахгүйгээр бүгд тэндээсээ очоод л авчихдаг. Элс хэрэгтэй бол элс авдаг газраасаа авчихдаг. Чулуу хэрэгтэй бол чулуугаа авчихдаг, хайрга, дайрга хэрэгтэй бол хайргаа бас яг тэндээсээ авчихдаг.

Тэгээд би бас Уянга гишүүнтэй бас санал нийлэх гээд байна л даа. Ер нь бол одоо байгаа зохицуулалтаараа хуулиа хэрэгжүүлэхгүй байгаад байгаа юм. Тэгээд яг энэ хуульд нэмэлт, өөрчлөлт ороод, энэ асуудлууд яг бүрэн шийдэгдэхгүй ийм зохицуулалт харагдаад байгаа юм л даа. Тэгэхээр яг энийг яг цогцоор нь харж уг нь шийдэхгүй бол орон нутагт бол бүгд дуртай газар, яг нөгөө авдаг авдаг газруудаасаа хэнээс ч зөвшөөрөл авах шаардлагагүйгээр аваад байгаа байхгүй юу. Тэгээд энийгээ бас бид нар яах юм бэ гэдгээ ярих хэрэгтэй. Өмнө нь бол тэрийгээ зохицуулж чадаагүй байхгүй юу. Одоо энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт орж ирснээрээ бас яг яаж зохицуулагдах нь тодорхойгүй харагдаад байна л даа.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Хайрга чинь бол хаднаас авч буталж хийх ёстой шүү дээ. Тэгвэл хамгийн сайн чанартай барилга хэзээ баригдах вэ гэвэл дайргаас баригдана л гэж байгаа. Хайрга бол зөвхөн зам энэ тэрд ордог тийм бүтээгдэхүүн байгаа. Манай Сангийн сайд бас хажуугаас тайлбар хүсэж байх шиг байна. Би бол ингэж бодож байгаа юм. Манай Улсын Их Хурлын гишүүд энэ хуулийг бас дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна. Ер нь бол энэ хуулийн дагаж мөрдөх журмын тухай хууль гэж гарна. Дагалдан өргөн барьсан. Энэ хуулиар 2026 оны эхний улиралд багтаж суурьшлын бүсээ тогтоо гэж байгаа юм. Аймаг, орон нутагт бол суурьшлын бүсээ тогтоогоогүй учраас нөгөө хууль хэрэгжүүлэх бололцоог Засаг дарга нар гаргахгүй байгаа. Тийм учраас дагаж мөрдөх журмын тухай хуулиар Засаг дарга нар, аймаг нийслэлийн бүх Засаг дарга нарт үүрэг өгч, бид энэ ажлыг хийлгүүлэх шаардлага тавьсан.

Уянга гишүүн, Бямбасүрэн гишүүн 2 ярьж байгаа. Өмнөх хуулиар явчих юм биш үү гэж. Тэр өмнөх хуулиар явах гэхээр 200 метр бол хангалтгүй байгаад байгаа юм. 200 метр гэдэг чинь та бүгд мэднэ шүү дээ. Голын эргээс 200 метр гэдэг чинь суурьшлын бүстэйгээ тулж ирчхээд байгаа байхгүй юу. Энэ хүмүүс дандаа тэнд амьдарч байгаа л хүмүүс. Тийм учраас энэ 200 метрийг зайлшгүй сунгах ёстой. Тэгээд энэ асуудлуудыг ер нь ганцхан Улаанбаатар хот ч биш, Монгол Улсын хэмжээнд энэ хайрга, дайргын олборлолтыг хуульчилж өгч шийдвэрлэхгүй бол болохгүй л гэж үзэж байгаа юм.

Тэгээд энэ хууль гарснаараа бас ялангуяа манай нийслэл хотод замбараагүй олгогдчихсон байсан. Та хэд маань Био, шувуу, сонгинын тэнд яваад үзэх юм бол

дайн болчихсон юм шиг байгаа. Тэгээд ажлын хэсэг нь тэр Байнгын хорооноос гараад, тэгээд тэр нөхөн сэргээлтийн асуудлыг бас нэмж дуусгах нь зөв юм болов уу гэж би бас бодож байна.

Р.Сэддорж: Бямбасүрэн гишүүн.

Ш.Бямбасүрэн: Хариулт дутуу байгаад байна. Тэр усан сан бүхий газрын хил хязгаарыг ер нь хаанаас тогтоодог юм. Би бол одоо бүр яг 1 аж ахуйн нэгжийг маш сайн мэдэж байгаа. Бүр хилийн заагийг нь бүр ингээд ухаж аваад, яг ингээд 1 аж ахуйн нэгжид эндээс бол гаргачихсан гээд өгчихсөн байгааг мэдэж байгаа. Тэгээд тэрийг ер нь нааш нь цааш татах эрх мэдэл нь хэнд байдаг юм бэ гэж асууя.

Р.Сэддорж: 4 номер.

О.Амарсанаа: Гишүүний асуултад хариулъя. Голын хил татам дэглэмийг бол Усны тухай хуулийн 22 дугаар зүйл дээр заасны дагуу бол журмаар зохицуулдаг байгаа. Журам дээр юу гэж заасан байгаа вэ гэхээр журмаар зохицуулна. Журмыг үндэслээд Засгийн газрын тогтоол гарч байгаа. Тэр тогтоолын хүрээнд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тэмдэг тэмдэглэгээ, хил заагийг бол бас тогтоож өгдөг ийм зохицуулалттай явж байгаа.

Р.Сэддорж: Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны иргэн Отгонбаатар. 7 номер та нөхцөл байдлыг хэлээч.

Г.Отгонбаатар: Энэ оройн мэнд хүргэе. Би Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны иргэн Гантөмөр овогтой Отгонбаатар гэдэг хүн байна. Манай тэнд бол Бөхөгийн гол гэж байдаг. Одоо Бөхөгийн голд би 2010 онд ирсэн. Одоо бол тэр амьдарч байгаа манай тэнд болохоор нөхөн сэргээлт хийгээгүй уул уурхайгаас болж энэ Бөхөгийн гол чинь карьер дундуур чинь хамт урсдаг. Тэгээд ямар ч ойр хавийн орчинд ер нь хүн байхад яах вэ, би өөрөө яг тэндээ амьдарч байгаа болохоор их хүнд л байдалтай байдаг л даа. Одоо би бүр цөхөө бараад өөрөө хөл дээр газраа гарчихсан ямар ч буух газаргүй цөхөө бараад сууж байна шүү дээ. Ерөөсөө ойр хавьд манай тэнд бол ерөөсөө хамгийн эмзэг асуудал байдаг. Хааш хаашаа 5км, 10км ерөөсөө ухаад үргэлжлээд явчихсан байдаг. Одоо хүн муу юм боллоо. Ажил явдал гарлаа гэж бодъё. Одоо гол ус нь ингээд нийлээд ороод ирдэг.../минут дуусав/

Р.Сэддорж: 7 номер дээр 1 минут.

Г.Отгонбаатар: Тэгээд ийм хүнд байдалтай байгаа орчинд нь байгаа хүн бол яг л бодит амьдрал дээр би өөрөө амьдардаг хүн. Тэгээд ерөөсөө л ганц нөхцөл байдал тэр ерөөсөө голын хойд тал, урд тал 2 нь тэр чигээрээ үргэлжлээд ухаад хаячихсан. 1 тэмтэрч тэмтэрч байгаа жоохон газар байдаг. Тэрүүгээр нь яах вэ бороо шороо ороогүй, үер ус ороогүй л гараад явчихдаг. Үер ус орохоо тэгээд нэг бол Төв аймгаараа явна. Нөгөө бол Алтанбулагаараа явна. Өөр явах ямар ч гарц байхгүй. Гүүрэн гарц гэж байхгүй. Тэгээд ийм л хүнд байдалтай байцгааж байна. Бид нар бол яг бодит амьдрал дээр. Тэгээд л хүний мал тэнд нөхөн сэргээлт хийгээгүй нэлийсэн ус байдаг. Тэр дотор ноднин айлын хэчнээн адуу унаж үхлээ шүү дээ. Бид нар татаад л гаргалаа. Тэгээд тэр хүмүүс нь хохирлыг нь барагдуулна л гэж байгаа юм. Тэгээд хохирол нь барагдуулж байгаа юм байхгүй. Тэгээд малаараа л хохирч байдаг. Хөөцөлдөөд байдаг. Өөр ямар ч арга байдаггүй ийм л байдалтай байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Анар.

Ч.Анар: Зарчмын хувьд Алдаржавхлан гишүүний хуулийн төслийг бол дэмжиж байгаа. 1 дүгээрт шалтгаан нь бол байгаль орчин, усны эх үүсвэр, усан сантай холбогдолтой маш их хохирол амсаж байгаа. Хэн бүхэн мэдэж байгаа.

2 дугаарт бол бас энэ өндөр даацын цемент зуурам дээр голын хайрга ашиглаад байгаа. Энэ нь өөрөө бага даац дээр л ашиглах ёстой. Ялангуяа зам дээр ашиглаж болохгүй. Тэр дээр бол дайрга ашиглах ёстой болохоос голын хайргыг ашиглах ёсгүй. Тэгэхээр энд хяналт байхгүй. Өнөөдөр манайд бол барилгууд бол 20 давхраас дээшээ болоод эхэлсэн. Ихэвчлэн дандаа энэ голын хайргыг ашиглаж байгаа буюу стандартад нийцэхгүй хайргыг ашиглаж байгаа. Тэгэхээр тэр агуулгаараа бол энэ тодорхой хэмжээгээр нөгөө өртөг зардлын хувьд цементийн зуурмагийн үйлдвэрүүд дандаа энэ Улаанбаатар Туул голын сав газраас хайрга олборлож ашиглаад байгаа. Гэхдээ энд 2, 3 асуулт байна. Ажлын хэсгийн ахлагчаас.

Энэ хууль дээр түгээмэл тархацтай гэж оруулсан байгаа ч гэсэн бусад ашигт малтмал, хайгуул олборлоход эрсдэл учрах уу. Энэ дээр яагаад ингэж асууж байгаа юм бэ гэхээр Усны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т зааснаар нуур цөөрөм, тойром, гол горхи, булаг шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл гээд байж болох бүх усны гадаргын эх үүсвэрийг бичсэн байгаа байхгүй юу. Энэ ч тийм байх ёстой байх. Гэхдээ үүгээрээ далимдуулаад орон нутгийн иргэдийн хурал бусад ашигт малтмалыг ашиглах, олборлох эдийн засгаа манай улс уул уурхайгаар тэлэх гэж байгаа тохиолдолд хязгаарлалт үүсэх юм биш үү. Хүндрэл үүсэх юм биш үү гэсэн санаа зоволт байгаа юм.

2 дугаар асуулт нь яг Бямбасүрэн гишүүн хөндлөө л дөө. Орон нутагт чинь өөрөө бас энэ бага даацын барилгын бүтээн байгуулалт хийх гэхээр хайрга дайрга олборлох зөвшөөрөл үнэхээр байдаггүй. Хийж болдоггүй. Энэ асуудлыг хэрхэн шийдэх вэ.

3 дугаарт нэгэнтээ сая орж ирсэн ажлын хэсгийн гишүүд болон иргэдийн төлөөлөл ярьж байна. Хэрэгжилт, хяналтаа тавьж чадахгүй байгаа тохиолдолд энэ хүрээ хязгаарыг нь ингээд нэмчихээр эсрэгээрээ нөгөө төрийн албаны авлига, хээл хахуулийн асуудал хүнд суртал бүр хүндрээд явчих юм биш байгаа гэсэн санаа зовнил байна. Энэ 3 асуултдаа хариулт авъя.

Р.Сэддорж: Хариулт Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Анар гишүүний асуултад хариулъя. Бусад ашигт малтмалтай бол хамааралгүй байгаа шүү дээ. Түгээмэл тархацтай хайрга, дайрга, элс, хүрмэн чулуу л гэж байгаа. Бусад ашигт малтмал бол ямар ч хамааралгүй. Зөвхөн эдгээр ашигт малтмалыг хязгаарлах асуудал яригдаж байгаа. Саяын ярьсан бусад хүндрэл учрах юм биш биз дээ гэдэг дээр зүгээр орон нутгийн Засаг дарга нар бол одоо хуулиа хэрэгжүүлэх ёстой. Тэр сая бас Бямбасүрэн гишүүн дурдаад байна. Суурьшлын бүсээ ерөөсөө Засаг дарга нь тогтоож өгөхгүй байгаа юм. Яг манай сумын суурьшлын бүс энэ гэдгийг энэ координатаас энэ координат гэдгийг ерөөсөө тогтоож өгөхгүй байгаа болохоор хууль хэрэгжиж өгөхгүй байгаа юм. Тийм учраас бид нар энэ хуулийг хэрэгжүүлэхийн тулд дагаж мөрдөх журмын тухай хуулиар 2026 оны эхний улиралд багтааж аймаг, нийслэл, сумын бүх Засаг дарга нар энэ суурьшлын бүсэд тогтоо гэдэг чиглэлийг энэ хуулиар өгч байгаа юм. Хууль

хэрэгжүүлэх даалгавар өгч байгаа юм. Тэгэхээр энэ бас хэрэгжээд явах байх гэсэн бодолтой байна.

Бусад зарим зарим жижиг сажиг асуудлыг бид нар ажлын хэсэг гаргаад бас зарим саналуудыг хүлээж авч ярилцах бололцоотой гэж үзэж байна.

Р.Сэддорж: Гүйцээж хэн хариулах вэ. Нэмж хариулах хүн байна уу. Хяналтыг нь яаж тавих вэ гэж байна шүү дээ. 4 номер.

О.Амарсанаа: Хяналттай холбоотой асуудал мэдээж салбарын хяналтын хариуцах асуудлын хүрээнд байгаа болохоор бас нэмэлт тайлбар алга байна.

Р.Сэддорж: 6 номер хариулъя.

Н.Мөнхбаяр: Хяналтын асуудал дээр бол мэдээж хайгуулын болон ашиглалтын лицензтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа явуулж байгаа. Байгаль орчны улсын байцаагч бол өдөр тутам нийслэлийн хэмжээнд хяналтаа тавиад явж байгаа. Энэ дээр ямар асуудал байдаг вэ гэхээр өмнөх аж ахуйн нэгжүүд буюу тэр 2014 оноос хойш хууль гарсантай холбогдуулаад ашиглалтын лицензээ цуцалчихсан аж ахуйн нэгжүүд хаяад явчихсан асуудал байж байгаа. Тэр асуудал дээр нь бол манайхаас шүүхийн нэхэмжлэл гаргаад, шинжээч томилуулаад, хохирлынх нь асуудлыг шийдүүлээд, шүүхэд өгөөд, тэгээд дараагийн арга хэмжээгээ аваад явах ийм зохицуулалтын л юм хэрэгжүүлж байгаа.

Р.Сэддорж: Анар гишүүн тодруулж асууна.

Ч.Анар: Тэгэхээр Алдаржавхлан гишүүн ярьж байна л даа. Энэ хамгаалалтын бүсийн заагаа сум орон нутаг, иргэдийн төлөөлөгчид нь тогтоохгүй байгаа. Тэгэхээр энэ 2014 онд батлагдсан хуульд хяналт хэрэгжилт дээрээ анхаарч чадахгүй байгаа гэж байна. Тэгэхээр энэ дээрээ маш сайн анхааралтай ажиллаад, хуулийн төслийг Монгол Улсын хууль, тогтоолын хэрэгжилт Их Хурлын дэргэдэх үнэлгээ мониторингийн газрын гаргасан дүгнэлтээр тогтоолын хэрэгжилт 22-27 хувь, хуулийн хэрэгжилт 33-38 хувь, хууль хэрэгжүүлэгч байгууллага, гүйцэтгэх засаглал, орон нутгийн удирдлага энэ хуулиа хэрэгжүүлэхгүй байгаа хэрэгжилт дээрээ анхаарахгүй байгаа. Тэгэхээр энэ дээрээ хуулийг ингээд өөрчлөөд үнэхээр зорилго нь бол зөв ч гэсэн эргээд миний хамгийн санаа зовж байгаа юм бол эргээд энэ нь бас хүнд суртал болж хувирах вий л гэдэгт санаа зовж байна. Тэрнээс энэ хуулийн агуулга, зарчмын хувьд бол дэмжиж байна. Энэ дээрээ дахиж анхаарахыг хүсье.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байна уу. Энэ бол бас хөнгөн хуумгай шийдэх асуудал бол биш. Сая та бүхэн олон жилийн өмнөх сонсгол дээр юу яригдаж байна. Эдийн засгийн байнгын хорооны тогтоол яригдаж байна шүү дээ. Тэгэхээр энд хэлсэн үг бүхэн Монгол төрийн энэ архивд хадгалагдаж, тэгээд эргээд бас тэрийгээ хамгаалах ийм цаг үе ирж магадгүй. Тэгээд энэ Дархан цаазтай газраас нийслэл авах гээд байна л гэсэн ийм хардлага л байгаа юм байна лээ. Дархан цаазтай газраас нийслэл авах эрх нь үүсэх гээд байна гээд. Тэгээд энийг бол та бүхэн бас энд тайлбарлах хэрэгтэй байх. Ер нь зовлонг бол ойлгож байна. Энэ зүүн тийшээ амралтын зочид гийчид аваад явахад тэр ямар аймар замын хажууд ухсан байна. Тэрийгээ нөхөн сэргээж байгаа л юм байна лээ. Тэгээд л тэр нь маш удаан. Тийм учраас энэ нөхөн сэргээлтийг бол давхар хийхгүй бол тийм хариуцлагагүй байж болохгүй байх. Тэгэхээр энэ дээр Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Энэ бол нийслэлд ямар ч хамааралгүй хууль. Богд хан уулын дархан цаазат газар бол угаасаа Тусгай хамгаалалтын хуулиар явж байгаа. Тэр чинь бүр координатаараа байж байгаа шүү дээ. Энэ хууль бол зүгээр л усны сав газар ашигт малтмал буюу түгээмэл тархацтай ашигт малтмал хэрэглэхийг хориглоё. Суурьшлын бүсэд бас ухахыг хориглоё л гэж байгаа юм. Тэрнээс биш тэр тусгай хамгаалалттай газартай огт хамаарал байхгүй. Тэр бол одоо бас хэтэрхий мөрөөдөж бодсон хүний бодол байна.

Р.Сэддорж: Байгаль орчны яам. 6 номер.

Н.Мөнхбаяр: Нийслэлийн, улсын хэмжээнд газрын нэгдсэн лэнд менежер гээд программ нэвтэрсэн. 2021 оноос хойш нэвтрээд явж байгаа. Энэ программ дээр ямар асуудлууд байдаг вэ гэхээр одоо яг усан сан бүхий хамгаалалтын газрын мэдээллийн санд координатжуулан оруулаад нийслэлийн Иргэдийн Хурлын 2017 оны 50 дугаар тогтоол, мөн 2024 оны 69 дүгээр тогтоол гэх мэтчилэн тогтоолуудыг яг координатаар нь оруулаад программчилсан байдаг. Тэгэхээр энэ программ дээр ямар асуудал байдаг вэ гэхээр нэмэлтээр тэр усан сан бүхий газар луу ямарваа нэгэн байдлаар кадастрын зураг гэж оруулах ийм тохиолдолд бол программ угаасаа анхнаасаа хүлээж авахгүй. Хүлээж авахгүй байна гэдэг маань ямарваа нэгэн зөвшөөрөл гарахгүй гэсэн үг. Тэгэхээр нэгдсэн системээрээ бас хяналтын тогтолцоо нь бас давхар хянаад явж байгаа.

Р.Сэддорж: Тэгээд сая гишүүд асуултаа асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.11 дэх хэсэгт заасныг үндэслэн хуулийн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Санал хураалт 1.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 65 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд унших гишүүн байна уу. Улсын Их Хурлын гишүүн Анар танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа.

16.56 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 2.

Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн томилгооны сонсголын тайланг хэлэлцэж эхэлье.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа уншиж танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Д.Үүрийнтуяа: Байнгын хорооны эрхэм гишүүддээ оройн мэнд хүргэе.

Монголбанкны ерөнхийлөгчид нэр дэвшигчийн талаарх сонсголын тайлан

Монголбанкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монголбанкыг Улсын Их Хурлаас томилогдсон Ерөнхийлөгч толгойлж, үйл ажиллагаагаа Улсын Их Хурлын өмнө хариуцан тайлагнана. Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилно гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо явуулна гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан дараах ажиллагааг хийлээ.

Нэр дэвшигч Санжаагийн Наранцогт нь Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 3 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2025 оны 11 сарын 25-ны өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасны дагуу “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” 18 дугаар тогтоолыг баталж 2025 оны 12 сарын 16-ны өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоож, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяаг сонгосон.

Сонсголын бэлтгэл хангах хүрээнд.

Нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан. Сонсголын тов хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудсаар хүргэсэн. Зарын дагуу сонсголд оролцохоор 22 оролцогч, 14 ажиглагч и-мэйлээр бүртгүүлж, асуултаа урьдчилан ирүүлсэн болно.

Эдийн засгийн байнгын хорооны гишүүдийн олонх нь сонсголд хүрэлцэн ирснээр ирц бүрдсэн бөгөөд 2025 оны 12 сарын 16-ны өдрийн 10 цагт Улсын Их Хурлын гишүүн Сэддорж, Үүрийнтуяа, Алдаржавхлан, Анар, Баатархүү, Батболд, Батнайрамдал, Батчимэг, Заяабал, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай,

Найдалаа, Одбаяр, Пунсалмаа, Соронзонболд, Ундраа, Уянга, Цэнгүүн нар хүрэлцэн ирж, ирц 61,3 хувь байсан.

Нэр дэвшигч Наранцогт нь тухайн албан тушаалд нэр дэвшсэн үндэслэл, томилогдсон тохиолдолд хийх ажил, боловсрол, ажлын туршлага нь тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан дараах оролцогчид асуулт асууж, хариулт авсан.

1.Оролцогч Нанжидсамбуу арилжааны банкны зээлийн хүүтэй харьцуулахад банк бус санхүүгийн байгууллагын зээлийн хүү харьцангуй өндөр байгааг багасгах боломжийн талаар, ирэх онд мөнгөний нийлүүлэлт багасахад төв банкны бодлогын хүүг инфляцтай уялдуулан бууруулах боломж байгаа эсэх талаар.

2.Оролцогч Буянхишиг инфляц мөнгөний чөлөөт урсгалын алийг барьж ажиллах талаар.

3.Оролцогч Банзрагч нэр дэвшигч хуульд заасан эдийн засаг, санхүү, удирдлагын мэдлэг, мэргэшлийн ур чадварыг хангах эсэх, хэрхэн мөнгөний бодлогын зорилтыг биелүүлж, инфляцыг тогтворжуулах, инфляцын зорилтот түвшнийг хадгалахад гол стратеги, валютын ханш, гадаад шок, төсвийн тэлэлт зэрэг хүчин зүйлийн талаар ямар хариу арга хэмжээ авах тухай. Санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд банкуудын эрсдэлийг яаж удирдах, IPO хийсэн банкуудын засаглалыг сайжруулах талаар юу хийх, Төв банк, Сангийн яамны хоорондын уялдааг хэрхэн оновчтой болгох, Мөнгөний бодлого, төсвийн бодлого зөрчилдөх үед ямар байр суурь баримтлах, финтек цахим төлбөр тооцоо, дижитал төгрөгийн бодлогын тухайд ямар байр суурь баримталдаг талаар.

4.Оролцогч Баярцог нэр дэвшигч Монголбанкны Ерөнхийлөгчөөр сонгогдвол банкны зах зээлийн өрсөлдөөнийг хангах, үнийг бууруулах чиглэлээр ямар бодлого баримтлах. Одоогийн 12 арилжааны банк банкны зах зээлд хангалттай өрсөлдөөн бий болгож байгаа эсэх, томилогдсон тохиолдолд инфляц чөлөөт хөрөнгийн урсгалын алийг онилсон бодлого хэрэгжүүлэх, гадаад валютын ханшийг тогтвортой байлгах, нөөцийг сайжруулах чиглэлээр баримтлах бодлого, хийх арга хэмжээнүүд, гадаадын банк Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх, тэдгээрт тавигдах шаардлагын талаарх хувийн бодлогын талаар.

5.Оролцогч Сонинтамир Засгийн газар төсвийн алдагдлын талаар Төв банктай хамтран ажиллах хэд хэдэн арга замуудаас Монголбанк алийг түлхүү ашиглаж ирсэн, хамтын ажиллагааг сайжруулах үүднээс ямар шинэчлэл хийх нь зүйтэй гэж үзэж байгаа талаар.

6.Оролцогч Мөнхбаяр Төв банкны хараат бус байдлыг хэрхэн хангаж ажиллах, төгрөгийн тогтвортой байдлыг хангахын тулд ямар ажлууд хийх талаар.

7.Оролцогч Бямбахорлоо Төв банкны алдагдлыг хэрхэн бууруулах, эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн салбарт ажиллаж байсан хүний хувьд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд ямар бодлого баримталж ажиллах талаар.

8.Оролцогч Гэрэлмаа өнгөрсөн хугацаанд ипотекийн зээл гаргахад баримталсан бодлого, өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа банкнуудын зээлийн бүтээгдэхүүний талаар, тэтгэврийн зээлийг 36 сар болгож сунгасан талаар.

9.Оролцогч Цэрэнжав банкны харилцааг нээлттэй арилжаалах талаар асуулт асууж, Зоос банкны хөрөнгийг Төрийн банк шилжүүлэн авах үйл ажиллагаа явуулж байгаа талаар, 625 жижиг хувьцаа эзэмшигчийн 58 тэрбумын хохирол өдий хүртэл төлөгдөөгүй асуудлаар.

10.Оролцогч Цэвэгмэд банкны салбарын хэт төвлөрлийг бууруулах талаар баримтлах бодлого, шинэ тоглогчийг дэмжих бодлого баримтлах эсэх, Монголд хурдацтай хөгжиж байгаа финтекийн салбарыг төв банк дэмжих эсэх, олон улсын банкнуудын чиг хандлагаас Монгол Улсад нутагшуулах боломжтой эсэх талаар.

11.Оролцогч Зоригтбаяр Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн дагуу зарим аж ахуйн нэгжүүдийн хууль бус үйл ажиллагааны талаар Банкны тухай хуулийн өөрчлөлтийн 1 хувьцаа эзэмшигчийн 20 хувиас дээш хувийг эзэмшихгүй байх хязгаарлалтыг хэрэгжүүлж чадах эсэх талаар болон харилцах дансны хүүг 3 хувиар тогтоосноос болж үүссэн гажуудлын талаар байр сууриа илэрхийллээ.

Мөн оролцогч Даваагийн Дөлгөөн зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах талаар, инфляцыг бууруулахаар төлөвлөж байгаа ажлуудын талаар, залилангийн болон санхүүгийн гэмт хэргийг бууруулах чиглэлээр иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхээр төлөвлөсөн ажлын тухайд, оролцогч Дөлгөөн төгрөгийн ханшийг тогтвортой байлгахад хэрхэн анхаарах, валютын нууцыг хэрхэн тогтвортой бүрдүүлэх IBAN дугаар өндөр настай иргэдэд ихээхэн хүндрэлтэй байгаа талаар, оролцогч Сумьяа, Одбаяр, Уламбаяр, Амар нарын оролцогчдоос асуусан асуултуудыг тавьж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын 14 гишүүн асуулт асууж, 2 гишүүн санал хэлсэн. Сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулсны дараа хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Нэр дэвшигчийн сонсголын тайланг та бүхэнд тараах материалаар хүргүүлсэн болно. Нэр дэвшигчээс ирүүлсэн материалд болон сонсголын үр дүнд үндэслэн нэр дэвшигчийг Монголбанкны Ерөнхийлөгчид тавигдах шаардлагыг хангасан гэж үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Санжаагийн Наранцогтыг Монголбанкны Ерөнхийлөгчөөр томилуулахыг дэмжсэн болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Сонсголын дүнг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Р.Сэддорж: Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.5-д заасныг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшүүлсэн талаар Улсын Их Хурлын дарга саналаа өөрийн биеэр танилцуулна. Улсын Их Хурлын дарга Учрал танилцуулна. Микрофоныг нээе.

Н.Учрал: Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанкны тухай хуулийн 26.1 дэх хэсэгт Монголбанкны Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлын даргын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилно гэж заасныг үндэслэн Санжаагийн Наранцогтыг Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж байна.

Санжаагийн Наранцогт 1973 онд Дундговь аймагт төрсөн. МУИС-ийн Физик математикийн сургуулийг 1990-1994 онд бакалаврын зэрэгтэй суралцаж, төгссөн. 1999-2001 онд тус сургуульд магистрын зэрэг хамгаалсан. 2005-2008 онд БНСУ-ын Сөүлийн Үндэсний их сургуульд докторын зэрэг хамгаалсан.

1993-1997 онд Шинжлэх ухааны академийн математикийн хүрээлэнд туслах, эрдэмж шинжилгээний ажилтан, 1994-1997 онд Шинжлэх ухаан, техникийн мэдээллийн төвд инженер, ахлах инженер, 1997-2000 онд Монголын Нээлттэй нийгэм хүрээлэнд хөтөлбөрийн зохицуулагч, 2000-2003 онд Ай Си компанид Ерөнхий менежер, 2003-2005 онд Санхүү, эдийн засгийн яаманд мэргэжилтэн, Хэлтсийн дарга, 2005-2008 онд БНСУ-ын Сөүлийн Үндэсний Их сургуульд докторант, 2008-2012 онд БСШУЯ-нд газрын дарга, 2012-2015 онд Хөдөлмөрийн яаманд газрын дарга, 2015-2017 онд Сангийн яаманд Газрын дарга, 2017-2021 онд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2021-2022 онд Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, 2022 оноос одоог хүртэл “Эрдэнэс Монгол” ХХК-д Гүйцэтгэх захирлын албан тушаалыг тус тус хашиж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчид нэр дэвшигч Санжаагийн Наранцогтыг дэмжиж өгөхийг хүсье.

Р.Сэддорж: Их Хурлын даргад баярлалаа. Нэр дэвшүүлэх эрх бүхий албан тушаалтны санал, нэр дэвшигчийн сонсголын тайлан болон нэр дэвшигчтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлангаар тасалж байна. Ирцийн дарааллаар Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан.

Ж.Алдаржавхлан: Наранцогтыг бас дэмжинэ. Нэлээн хэдэн жил бас хамт ажиллаж байсан. ер нь бол мэднэ. 2, 3 зүйлийг Наранцогтоос бас асууя гэж бодоод байгаа юм.

Одоо Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор бид нар ипотекийн зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг судлах ажлын хэсэг ажиллаад явж байгаа. Сая хэд хоног завсарласан. Тэр дээр Монголбанк маш дутагдалтай оролцсон. Энэ дээр та Монголбанкны Ерөнхийлөгчөөр сонгогдох юм бол бас идэвхтэй оролцмоор байна. Өнөөгийн нөхцөл байдал, ипотекийн зээлийн асуудлыг судалж, орон сууцныхаа эрэлт нийлүүлэлттэй уялдуулахгүй бол хүссэн хэмжээгээр зээл гаргачихаар орон сууцны үнэ өсчхөөд байна. Тийм учраас ипотекийн зээлийн асуудлыг 1 дүгээрт зориулалт болоод анх удаа орон сууц авч байгаа хүмүүс эсхүл баригдаж байгаа тэр Барилга, хот байгуулалтын яамтай хамтарч ажиллаж, зах зээлийг сайн судалж, яг эрэлт нийлүүлэлтийг нь уялдуулж зээл олгомоор байгаа юм. Тэгээд Монголбанк бол энийг сайн анхаарч ажиллах ёстой гэж. 1 дүгээрт энэ дээр бас өөрийн чинь бодол юу байна гэж.

2 дугаарт Монголбанкны Ерөнхийлөгч бол Монгол Улсын Их Хурлаас томилогдсон төрийн бас том албан тушаалтан. Хуучин манай Ерөнхийлөгч нар бол ерөнхийдөө Ерөнхий сайдын дүү шиг ажиллаж ирсэн. Тоглоомоор хэлэхэд бол одоо

далайсан газар нь далд орж, далласан газар ил гарч явсан. Тэгэхээр та бас өөрийн байр сууриа Засгийн газар дээр хамгаалж чадах уу гэсэн ийм 2 асуулт байна.

Р.Сэддорж: Хариулт Наранцогт нэр дэвшигч. 5 номер.

С.Наранцогт: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Ипотекийн ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Засгийн газар Монголбанкны хооронд бас ажлын хэсэгт гишүүд ороод тодорхой хуулийн төсөл боловсруулаад ингээд ажлын хэсэг дээрээ яриад явж байгаа гэж ойлгож байгаа. Би тантай бол бас санал нэг байна. Ер нь өглөөний хэлэлцүүлгийн үеэр ч гэсэн бид нэлээд ярьсан. Өөрөөр хэлэх юм бол энэ ипотекийн зээл дээр Төв банк, Засгийн газраас нэлээдгүй анхаарал тавьж, 2013 оноос хойш хэрэгжүүлж, 7 их наяд төгрөгийг хэвлэж, хөтөлбөрийг санхүүжүүлсэн. Бодит байдал дээр бол яг энэ Улаанбаатарын гэр хорооллын 40 хувь нь орон сууцажсан. Үлдсэн хэсэг нь бол 2 дахь, 3 дахь орон сууцыг авсан. Тэдгээр орон сууцны бас нэлээд дийлэнх хувь нь Хан-Уул дүүрэгт олгогдсон байна гэдэг ийм шүүмжлэл явж байгаа. Тэгэхээр бид бид яах вэ гэхээр одоо явж байгаа тэр хуулийн төслөөрөө бол ер нь өнөөгийн нөхцөл байдал дээр банкнуудын өөрийн хөрөнгөөр олгосон бас орон сууцны зээл нэлээдгүй 60-аад хувь болчихсон. Өөрөөр хэлэх юм бол бас яг 6 хувийн хөнгөлөлттэй хөтөлбөрт хамрагдахгүй, үүнээс илүү орлоготой ийм иргэдийн хэрэгцээ байгаа учраас бид нар нэг талдаа энэ яг зорилтот бүлэгтээ төрөөс хэрэгжүүлж байгаа хөтөлбөрөө их нарийн чиглүүлэх, өөрөөр хэлэх юм бол гэр хороолол, янданг бууруулах, газар чөлөөлөлт гэж нийслэлд явуулж байгаа бодлого ер нь чиглэсэн. Нөгөө талдаа бол энэ орлогын түвшин боломжтойг энэ хүүгийн түвшнээрээ зах зээлийн зарчмаар зохицуулах энэ сонголтыг бас давхар бий болгох хэрэгтэй. Энэ нь тэгээд өөрөө яг олон улсын орон сууцны зах зээлийн зарчмаар явах ёстой гэсэн ийм бодлоготой байна.

Тийм учраас энэ орон сууцны хөтөлбөрийн хувьд бол Монголбанкнаас цаашдаа энэ тусгай хөтөлбөрийн хүрээнд бол ажиллах 1 чиглэл бол мөн гэж ингэж бодож байгаа. Тэгэхдээ мэдээж цаашдаа бол ноднин жилээс эхлээд Үндэсний баялгийн сангийн хууль батлагдсантай холбоотой мөнгө хэвлэхээ бол больсон. Энэ бол сайн тал. Цаашдаа ч гэсэн энэ бодит мөнгөөр хэрэгжих, цаашдаа ногоон зээл, урт хугацааны хөнгөлөлттэй эх үүсвэр татдаг энэ механизмд нь Монголбанк шууд бус зохицуулалтын байдлаар оролцох ийм шаардлагатай гэж ингэж үзэж байгаа.

Төв банкны бие даасан байдлын хувьд бол хууль, эрх зүйн хүрээнд бие даасан байдлыг хангаж ажиллана гэж бодож байгаа. Тэгээд энэ дээр бас энэ төрд олон жил ажилласан туршлагын хувьд бас байгаа бодит асуудлыг бол энэ Их Хурлынхаа гишүүд, Байнгын хороо, Ерөнхий сайдын түвшинд бол ойлголцож, ойлгуулж ажиллах бас бололцоотой. Тэрнээс биш ер нь би сонсголын үеэр тусгай төсвийн болоод хагас төсвийн үйл ажиллагааг бол Монголбанк дээр явуулах нь бол буруу. Энийг бол зохицуулалтын хүрээнд шууд бусаар, тодорхой яг асуудал дээр яг өөрийнхөө хуулиар олгогдсон мандатын хүрээнд хийгдэх ажлын хүрээнд л оролцох нь зүйтэй юм гэсэн ийм байр суурьтай байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай.

М.Мандхай: Наранцогт даргыг дэмжиж байгаа. Тэгээд яах вэ, гол таныг бас төвлөрч бас ажиллаасай гэсэн 2 санал болон бас үүнтэй зэрэгцүүлээд бас тодруулах асуулт байна.

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар өрхийн дундаж орлого 2,6 саятай, зарлага бол 2,7 буюу бараг 100 мянган төгрөгөөр ийм хасахтай байгаа. Тэгээд үндсэндээ бол хуримтлал хийх ийм боломжгүй нөхцөлтэй дундаж давхарга болон түүнээс доош ийм нөхцөл байдалтай. Төлбөрийн чадвар өөрөө сөргөөр нөлөөлж байгаа нөхцөл байдалтай байгаа. Тэгэхээр энэ 6 хувь гэдэг асуудал бол өөрөө үндсэндээ өрхүүд хуримтлал үүсгэх чадваргүй, тэгсэн мөртөө 6 хувийн хүүтэй зээл авах эрэлт нь өндөр мөртөө үүнээсээ болоод орон сууцны энэ үнийг хөөрөгдүүлэх ийм эрсдэл үүсээд байгаа. Тэгэхээр нөгөө энэ хүчин зүйл дээр түшиглээд иргэдийг илүү улам өндөр өртөгтэй болгоод байгаа ийм эрсдэл байгаа. Тэгэхээр энэ ипотекийн хөтөлбөрийн зорилго нь өөрөө нэг бол орон сууцжуулах гэж байна уу. Эсвэл иргэдийн бодит санхүүгийн ачааллыг бууруулах уу гэдэг ийм 2 асуулт өрнөөд байгаа. Тэгэхээр хэрэв ачааллыг бид нар бууруулах юм бол зээлийн хүүг илүү үү уян хатан шатлалтай, зах зээлийн нөхцөлд ойртуулах ямар боломж байна. Орон сууцны үнийг тогтворжуулах арга хэмжээг хэзээнээс эхлүүлэх вэ гэдэг асуулт байна.

2-т нь болохоор төрөлжүүлэн хөгжүүлэх хүүгийн бодлоготой байх. Ялангуяа яах вэ, бага орлоготой иргэдэд бол ойлгож байна. 6 хувийн хүүтэй хөтөлбөрийг хэрэгжүүлээд явах нь зүйтэй 80м² хүртэл. Гэтэл дундаж болон түүнээс дээш орлоготой иргэд заавал 6 хувийн хүүтэй гэхгүйгээр 80-аас дээш магадгүй 120, 150м² талбай бүхий гэхдээ 6 хувь гэхгүй магадгүй 8, 9 хувийн шатлалтай хүүтэйгээр илүү хүртээмжтэй ипотекийн зээлд хамрагдах хүсэл бол байдаг. Тэгэхээр энэ дунджаас дээш орлоготой зээлийн хүүг зах зээлийн нөхцөлд илүү ойртуулах замаар энэ хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх тодорхой төлөвлөгөө гарах уу. Ер нь таны бас бодож байгаа төлөвлөгөөнд энэ зэргийн төлөвлөгөө тусгагдах уу гэдгийг асууя гэж бодож байна.

3 дугаарт бид нар нөгөө орон сууцны урт хугацааны тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хэрэгжүүлэх бол зайлшгүй шаардлагатай байгаа. Тэгэхээр мэдээж ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гээд олон удаа ярьж байсан. МИК ч гэсэн энэ талаар бас .../минут дуусав/

Р.Сэддорж: 5 номер.

С.Наранцогт: Мандхай гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр таны хэлж байгаа орон сууцны үнэ иргэдийн амьжиргааны зөрүү гарч байгаа нь суурь шалтгаан бол инфляц. Тэгэхээр үндсэндээ инфляц мөнгөний үнэ цэн гэсэн үг. Инфляц бол өөрөө сагсан дээр тооцогдоод явж байгаа. Тэгэхээр өнгөрсөн хугацааны энэ жоохон хөөсрөлт бий болоод, бодит эдийн засгийн өсөлтөөс илүүдсэн зээл, мөнгөний нийлүүлэлт, төсвийн өсөлт, тэлэлт энэ болгон бол яаж шингэж байгаа вэ гэхээр 1 дүгээрт инфляц руу, 2 дугаарт тодорхой салбар үнийн өсөлт рүү шингэж байгаа юм. Тийм учраас ингээд дээр нь нэмээд мэдээж таны хэлж байгаа энэ ипотекийн 6 хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл. Энэ бүгд нийлээд орон сууцны үнийг хөөрөгдөж байгаа.

Тийм учраас энийг зах зээлийн зарчимд шилжүүлээд, мэдээж орлогын хувьд бололцоотой хувьд заавал 6 хувь дээрээ бөөнөөрөө ингэж очерлох биш төрөлжсөн бүтээгдэхүүнийг гаргах ёстой. Энэ бол яг энэ шинээр явж байгаа хөтөлбөр, хуулийн төсөл, ер нь цаашдаа ч энэ зах зээл дээр зайлшгүй бий болгох шаардлагатай ийм зүйл. Тийм учраас та сүүлд нь тодруулах гээд хэлж байгаа тэр олон улсад хэрэгждэг механизм нь одоо ч 6 хувь дээрээ явж байгаа. Энэ нь ч гэсэн цаад талынхаа шинээр бий болох зах зээл дээрээ мөн адилхан схем үргэлжилж явдаг л энэ практикаараа явна гэсэн үг. Тийм учраас энэ зүйлийг ингээд зэрэг хийхгүй бол хэрэглэгчдэд

сонголт өгөхгүй, нэгийг нь хаах бас хүндрэлтэй. Гэхдээ тэртээ тэргүй энэ дээр маш их очер үүсчихсэн, нэлээдгүй хэмжээний очер үүсчихсэн ийм нөхцөлд бол яг энэ бодлогоор явуулж байгаа энэ 6 хувийн хөтөлбөрийг бол маш нарийн фокустай, тэр зорилтот бүлэг гэдгээ маш нарийн тодорхойлж, яг тэр лүүгээ чиглүүлээд зэрэгцүүлээд таны яг ярьж байгаа энэ зах зээлийн нөхцөлд тулгуурласан энэ орон зайг нөхөх энэ тогтолцоог бол бүрдүүлэх ёстой гэж ингэж үзэж байгаа юм.

Тийм учраас энэ ажил бол мэдээж эхлээд явчихсан учраас энэ рүү шуурхай ажиллана. Түрүүн Алдаржавхлан гишүүн хэлж байсан. Ажлын хэсэг дээр бид нар хойрго хандах ёсгүй энэ дээр бол идэвхтэй оролцож ажиллана. Манлайлж оролцож ажиллана гэж бодож байна.

Р.Сэддорж: Мандхай гишүүн.

М.Мандхай: Тантай бас санал 1 байна. Инфляцтай уялдаад ерөнхийдөө энэ үнийн хөөсрөлт гэдэг юм бас үүсэж байгаа учраас эргээд нөгөө ипотекийн зээл гаргах, тэгээд нөгөө эрэлтдээ нийцэж зээлүүдээ гаргах асуудал бол хязгаартай байгаад байна шүү дээ. Тэгэхээр бид нарын хувьд бол зүгээр яг ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гээд би түрүүн хэлсэн. Гол нь төсвөөс хараат бус ипотекийн зээлийг төсвөөс хараат бус байлгах зайлшгүй шаардлага байгаад байгаа. Тэгэхээр нөгөө инфляцтай уялдуулаад, төсвөөс хараат болчихоор мөнгөний хязгаарлалт ингээд үүсээд ипотекийн зээл яг эрэлтдээ нийцэж гарахгүй гээд ерөөсөө ийм чөтгөрийн тойрог дунд орчхоод яваад байдаг. Тэгэхээр таны хувьд энэ урт хугацааны санхүүжилтийг олон нийтээс мөнгө босгоод магадгүй энэ ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр гаргах, мөнгө татах тал дээр яг ямар стратеги байгаа/минут дуусав/

Р.Сэддорж: 5 номер. Нэр дэвшигч.

С.Наранцогт: Тэгэхээр яг л энэ нөгөө олон улсад явдаг тэр схемээрээ явна. Тэгж байж энэ дээр урт хугацааны, хөнгөлөлттэй ийм эх үүсвэр олж ирээд, тэгээд энэ нь ипотекийн зээлд гараад, энэ зээлээ ипотекээр баталгаажсан үнэт цаас нь эргэлтэд ороод ингэж явдаг. Таны хэлж байгаа яг энэ бол нөгөө орлогод суурилсан, яг зах зээлийн зарчимд суурилсан энэ бүтээгдэхүүн бол өөрөө үүсээгүй. Яг энэ зарчимдаа орно гэсэн үг. Тэгж байж яг зах зээлийн зарчмаар хүү тогтоно. Тэгж байж эрэлт нийлүүлэлт тэнцээд явна. Энэ дээр нь бол төр оролцохгүй. Мэдээж төр бол яг тодорхой бодлогоор энэ зорилтот зах зээлийн дээр бид нар явж ирсэн. Тэрийгээ л яг нарийвчилж ингэж явах энэ бодлого дээрээ л төр оролцож явах нь зүйтэй байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр хэлж байгаа. Зүгээр ер нь яах вэ, инфляцын хувьд бол мэдээж Монголбанкны үндсэн мандат учраас энэ дээрээ бодлогоороо .../минут дуусав/

Р.Сэддорж: Мандхай гишүүн хариулт хангалтгүй гэж 1 минут.

М.Мандхай: Тэгэхээр нөгөө олон улсын жишгээр яг энэ ипотекийн зээлийн одоо баталгаажсан үнэт цаасыг ер нь бас судалж гаргах нь зайлшгүй шаардлагатай. Үүнийг гол ажлын 1 нь бас байгаасай гэж хүсэж байгаа. Гэхдээ одоогийн яг энэ бизнесийн орчны нөхцөл байдалтай уялдуулах юм бол хэрэв үнэт цаас гаргахаар болох юм бол энэ олон нийтээс эх үүсвэр татахад татварын хөнгөлөлт эсвэл Засгийн газрын баталгаа ч гэдэг юм уу ийм хөшүүрэг бий болж байж энэ өөрөө идэвхжих боломжтой болох байх. Хөрөнгө оруулагчид илүү таатай орчныг бий

болгосны дараа гаргахгүй бол яг одоо ингээд гаргалаа гэхэд худалдан авагч, хөрөнгө оруулагчид бол илүү бас хумигдмал байх болов уу гэсэн ийм санал байна.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Жавхлан.

Б.Жавхлан: Баярлалаа. Нэр дэвшигч Наранцогтыг дэмжиж байгаа. Сангийн бодлого, мөнгөний бодлого нийцтэй ажиллах ямар чухал байдаг вэ гэдгийг, ямар үнэ цэнтэй байдаг вэ гэдгийг өнгөрсөн жилүүд харуулсан гэж бид харж байгаа. Тийм учраас яг энэ нөхцөл байдалд хамгийн тохиромжтой кандидат гэж бас харж байгаа өөрийг чинь. Эдийн засаг, төсөв, санхүүгийн гол яамнуудаар Төрийн нарийн бичгийн дарга, дэд сайдын албыг хашлаа. “Эрдэнэс Монгол” гээд Монгол орныг сүүлийн 50 жил авч явж байгаа уул уурхайн эдийн засаг, аж ахуйг сүүлийн жилүүдэд хөдөлгөлөө. Баялгийн сан дээрээ менежмент хийх энэ нарийн мэдрэмжүүдийг авсан байх гэж би итгэж байгаа. Тийм учраас их сайн ажиллаарай.

Ипотекийн зээл гэж гишүүд их асууж байгааг анхааралдаа аваарай. Сая яг өөрөө их зөв хэллээ. Хамгийн гол нь зорилтот бүлэг рүүгээ л чиглүүлэх хэрэгтэй. Тэгэхгүй 80м²-аас дээшээ нөгөө боломжтой хүмүүс нь энэ рүүгээ гүйж орж ирээд нөгөө боломжгүй яг зорилтот хэсгээсээ боломжийг нь булааж авчхаад байгаа байхгүй юу. Тийм учраас энийгээ маш сайн нарийн барьж улам нарийсгаарай гэж захъя. Тэгээд ажлаа аваад удахгүй ханцуй шамлан ажилдаа орох байх. Ер нь гадна талд тодорхойгүй нөхцөл байдал 2026 онд үргэлжлэх төлөвтэй байна. Ер нь нэлээн тийм сорилт өөрийг чинь бол тосож байгаа. Тэгээд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн болоод ажиллаад явах учиртай. Тэгээд томилогдох ажилд нь Улсын Их Хурал дэмжинэ байх гэж би итгэж байна. Тэгээд ажилд нь амжилт хүсье.

Р.Сэддорж: Улсын Их Хурлын гишүүн Анар.

Ч.Анар: Наранцогт даргаас 2 асуулт асууя. Гадаад нөхцөл байдал сая хэцүүдэж байна гэж Жавхлан сайд дурдлаа. Геополитик хүндэрч байна. Дэлхийн олон төвт туйл руу шилжиж эхэлж байна. Тэгэхээр валютын сангийн сагсыг бид нар дан доллароор бүрдүүлэх үү. Эсвэл юань, рублиэр бүрдүүлэх ёстой юу. Та юу гэж бодож байгаа вэ. Геополитикийн нөхцөл байдал хүндэрч байгаа.

2 дугаарт олон улсын төлбөр тооцоо хүндрэлтэй байгаа санкцад бид нар албан бусаар орчихсон байгаа. Тэгэхээр та Си Би Ди Си-г ер нь юу гэж бодож байгаа вэ. Энэ дээр ямар бодлого баримтлах вэ. 2 хөрш маань аль хэдийн туршилтаа хийгээд дуусчихсан. 1 өдөр бүх төлбөрөө Си Би Ти Си-ээр хийнэ гэхэд бид нар бэлэн үү. Та энэ дээр бас ямар байр суурь Монголбанк энэ гадаад геополитикийн нөхцөл байдал дээр ямар бодлого баримталж ажиллах вэ.

Р.Сэддорж: 5 номер.

С.Наранцогт: Анар гишүүний асуултад хариулъя. Тантай санал 1 байна. Мэдээж бид нар энэ гадаад нөхцөл байдлыг геополитик, болзошгүй эрсдэлийг бол тооцоолж байх ёстой. Мэдээж бид нарын ирэх онуудад хүлээгдэж буй өр төлбөрийн асуудлууд бүгдээрээ Америк доллартой. Дэлхий дээрх энэ зах зээлийн хувьд бол Америк доллар давамгайлсан нөхцөлд бол валютын нөөц давамгайлж Америк доллар явах нь бол ойлгомжтой. Гэхдээ бол энэ яг худалдааны гол түншүүдийн ашиглаж байгаа трендийг бол бид нар бас бодолцох ёстой. Тэгэхээр Портвалио-ийн талаар бол энэ дээр тооцоо судалгаатай хандаж, төрөлжүүлэх чиглэл рүү ажиллана гэж ингэж бодож байна. Одоо ч гэсэн ер нь бас тодорхой хэмжээнд төрөлжчихсөн

манай валютын нөөц бол явдаг гэж би ингэж ойлгож байгаа. Тийм учраас тэрүүгээр явж байна.

Та Си Пи Ди Си-г асуулаа. Төв банкны тоон тэмдэгттэй гүйлгээнд ашиглах. Тэгэхээр төв банк дээр одоо бол төв банкны Стэйбл койн гэдэг ажил дээр бас судалгааны баг гараад ажиллаж байгаа юм байна гэсэн би ерөнхий мэдээлэлтэй байна. Ер нь мэдээж энэ чиглэл рүү хандлага явж байгаа учраас ялангуяа гадаад төлбөр тооцоон дээр хэрэглэгдэх ийм тохиолдолд бид нар энд бэлэн байх ёстой. Тийм учраас одоо бол би яг тодорхой ажил бол энэ төв банк дээр хийгдчихсэн гэж ойлгоогүй, хийгдэх талаар судалгаа хийгдэж байгаа юм байна гэсэн ойлголттой байна. Тийм учраас энэ дээр бид нар бас төвлөрч ажиллах ёстой. Хэлэлцүүлгийн үеэр ч гэсэн ер нь энэ санхүүгийн зах зээл дээрх финтек, орчин үеийн технологи, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нөгөө талдаа хэрэглэгч болоод харилцагчийн аюулгүй байдал, үүний аюулгүй байдлыг хангах чиглэл дээр давхар бид нар ажиллах ёстой гэсэн ийм бодолтой байна.

Р.Сэддорж: Анар гишүүн тодруулж асууна.

Ч.Анар: Си Би Ди Си буюу Төв банкны цахим төлбөрийн хэрэгсэл. Тэгэхээр энийг ноднин 2024 онд би Монголбанкныхнаас асууж байсан. 2 хөрш маань бол бэлэн байдалтай болчихсон байгаа. Эхнээсээ гүйлгээнд оруулаад эхэлчихсэн. Улс хоорондын төлбөр тооцоо, хамтын ажиллагаатай стратегийн түнш улсууд дээрээ. Тэгэхээр таныг Монголбанк дээр очоод технологи дээр суурилсан дэвшилтэт бодлогуудыгаа хэрэгжүүлээд, болзошгүй эрсдэлээс сэргийлээсэй гэж хүсээд амжилт хүсье.

Р.Сэддорж: Нэр дэвшигч Наранцогт дарга бол Сангийн яаманд ажиллаж байсан. Бас “Эрдэнэс Монгол” компанид ажиллаж байсан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын мөнгөн хөрөнгийг арвижуулах, зарцуулах чиглэлийн албан тушаалуудыг хашиж ирсэн. Таны ажиллаж байсан “Эрдэнэс Монгол” бол Монгол Улсын гадаад валютын 80 хувийг оруулж ирдэг ийм олон төрийн өмчийн компаниудын нэгдэл байгаа. Одоо тэгвэл тэрхүү мөнгөн хөрөнгийг хадгалах, зохицуулах чиглэлийн албан тушаалд та нэр дэвшиж байна. Тэгээд энэ асуудлыг цогцоор нь харах, шийдвэрлэх боломжийг та сонгогдвол танд олгоно. Тэгээд энэ их мэдлэг, туршлагынхаа хүрээнд таныг энэ үүргийг бас хангалттай биелүүлж, гүйцэтгэж чадна гэдэгт бас итгэж байгаа. Тэгээд та бол хамгийн гол нь туршлагатай хүн. Монголбанк бол маш эмзэг цэг. Та зөв алхам хийвэл Монгол Улсын хөгжил дэвшилд маш хэрэгтэй зүйлүүд урган гарна. Маш том баг байгаа. Мэргэжлийн баг хамт олон байгаа. Тэгээд хамгийн гол захих зүйл бол Монгол төгрөгийн чадавхыг үнэгүйдүүлэхгүй, улсын мөнгөн хөрөнгө, санхүүгийн өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр сайн ажиллахыг хүсье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалт.

1.Монголбанкны Ерөнхийлөгчөөр Санжаагийн Наранцогтыг томилуулахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Бядрангийн Лхагвасүрэнг Монголбанкны Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлөхийг дэмжье

гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалтын дүнд үндэслэн боловсруулсан тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Монголбанкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсэг, Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монголбанкны Ерөнхийлөгчөөр Санжаагийн Наранцогтыг томилсугай.

2.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Монголбанкны Ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас Бядрангийн Лхагвасүрэнг чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төсөл дээр саналтай гишүүд байна уу. Алга байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэж дууслаа. Нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн миний бие танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж, хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

17.32 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ